



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,  
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,  
Улаанбаатар хот, 13381  
Утас/Факс: (976-51) 26 00 62  
Цахим шуудан: info@spa.gov.mn  
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024.05.07 № А-2/1933  
танай 2024.04.30 -ны № 03/759 -т

**Хариу хүргүүлэх тухай**

Танай ирүүлсэн тодруулга авах тухай албан бичигтэй танилцаж дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

1. Цахим системийн “Техникийн санал бэлтгэх” хэсэгт тухайн тендер шалгаруулалтад илгээхээр бэлтгэсэн тендерийн материалыг хавсаргана. “Санхүүгийн санал бэлтгэх” хэсэгт санал болгож буй үнийн саналын мэдээллийг холбогдох талбарт оруулж, тендер илгээх үйлдлийг хийнэ.

2. Гадаад улсын банкны баталгааг бүртгэх харилцааг Сангийн сайдын 2023 оны А/252 дугаар тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-аар зохицуулсан бөгөөд журмын 4.3, 4.3.1, 4.3.2-т заасны дагуу Монгол Улсад үүсгэн байгуулагдсан банк, санхүүгийн байгууллагаар дамжуулан цахим системд илгээнэ;

Монгол Улсад үүсгэн байгуулагдсан банк, санхүүгийн байгууллага журмын 4.3.2-т заасныг хэрэгжүүлэхэд техникийн шийдлээс шалтгаалан цахим системд илгээх боломжгүй бол манай газарт хандсаныг үндэслэн дэмжлэг үзүүлэн ажиллах боломжтой.

3. Тендерийн баталгааны маягтын тендер шалгаруулалтын дугаар заавал кирилл үсгээр байх шаардлагагүй.

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.БУЯННЭМЭХ

9020020105 СБТ-11261 6529909

1324025246